


ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС (2015-01 САР)

Үл хөдлөх хөрөнгийн “Тэнхлэг зууч”, “Актив зууч”, “Монголиан пропертис” компаниудын консорциум нь “Орон сууцны үнийн индекс”-ийг хараат бусаар тооцоолон, танилцуулж байна. Энэхүү тооцоо, судалгаанд тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ, хуучин 4287 орон сууцны үнийг хамруулсан болно.

ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС


2015 оны 1 дүгээр сарын байдлаар орон сууцны үнийн индекс сүүлийн 6 сарын турш бууралттай гарсан нь орон сууцны үнэ дунджаар өмнөх сараас 1%, сүүлийн 6 сард 5.8%, сүүлийн 12 сард 2.2%-иар буурсан байна.

ЗУРАГ 1: УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС



Сүүлийн 6 сард шинэ орон сууцны үнэ бага зэрэг буурч харьцангуй тогтвортой байсан бол хуучин орон сууцны үнийн бууралт үргэлжилж байгаа нь орон сууцны үнэ буурахад нөлөөлжээ.

ЗУРАГ 2: ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКСИЙН ЖИЛИЙН ӨСӨЛТ



Орон сууцны үнийн жилийн өсөлт 2014.3 сард хамгийн өндөр буюу 23.7% хүрч байсан бол 2014.4 дүгээр сараас эхлэн өсөлт нь саарч, сүүлийн хоёр сард бууралттай гарсан байна.

Жишээ: БЗДүүргийн 25-р хороо, 13 хорооллын “Ногоон төгөл” хотхонд 2014.7 сард 1 м² дундаж үнэ 2,476,000 төгрөг байсан бол 2015.1 сарын байдлаар 2,384,900 төгрөг болж 4%-иар буурсан байна.


1. Шинэ орон сууцны үнэ¹

Шинэ орон сууцны 1м.кв дундаж үнэ нь 2015 оны 1 дүгээр сарын байдлаар 2,160,000 төгрөг болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.7 хувиар буурсан дүнтэй байна.

ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ-ИЙН ДУНДАЖ ҮНЭ /2015.01/


Орон сууцны дундаж үнэ	2,160,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-1.7%
Сарын өсөлтийн хувь	0.5%
Хамгийн өндөр үнэтэй	Сүхбаатар
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан

ЗУРАГ 3: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сая.төгрөг/



Сүхбаатар дүүрэгт шинэ орон сууцны 1м.кв-ийн дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 4: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /САЯ ₮/




2. Хуучин орон сууцны үнэ – 2 өрөө байр

Хуучин 2 өрөө байрны дундаж үнэ² нь 2015 оны 1 дүгээр сарын байдлаар 97,800,000 төгрөг болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.0 хувиар буурсан дүнтэй байна.

ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /2015.01/


Орон сууцны дундаж үнэ	97,800,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-4.0%
Сарын өсөлтийн хувь	-0.9%
Хамгийн өндөр үнэтэй	Сүхбаатар
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан

ЗУРАГ 5: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /САЯ ₮/



Сүхбаатар дүүрэгт хуучин 2 өрөө байрны дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 6: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ, ДҮҮРЭГ /САЯ ₮/



¹ Байрны гэрчилгээ нь гараагүй бол шинэ орон сууц.

² 2000 оноос өмнөх хуучин орон сууцны үнэ (дүүргүүдийн дундаж үнэ)

Эх сурвалж: “Тэнхлэг зууч”, “Актив зууч”, “Монголиан пропертис” компаниудын консорциумын сар бүрийн тооцоолол